**МОНГОЛБАНКНЫ**
**ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ**

2016 оны 12 сарын 21 өдөр  Дугаар А-352  Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 68 дугаар тогтоол, "Монголбанкны ажлын төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих заавар"-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, Монголбанкны 2017 оны дотоод ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус батлалсугай.

2.Хариуцсан газар (хэлтэс, алба, төв), бие даасан нэгж, орон нутаг дахь хэлтэс (салбар), ажилтан тус бүрээр ажлын нарийвчилсан төлөвлөгөө батлан хяналт тавьж ажиллахыг газар, бие даасан нэгжийн захирлуудад тус тус үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөний биелэлтийг улирлаар дүгнэж, Ерөнхийлөгч, Тэргүүн дэд Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч нарт тухай бүр нь танилцуулж байхыг Тамгын газар (П.Эрдэнэтуяа)-т, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Ж.Батхуяг)-т тус тус даалгасугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ  Н.БАЯРТСАЙХАН

14 2587

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны ..12 дугаар сарын ..21.. өдрийн ..А-382 дугаар тушаалын хавсралт 1

# ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2017 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Чиглэл | № | Хийж гүйцэтгэх ажлууд | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцан гүйцэтгэх газар, алба |
|---|---|---|---|---|
| **УИХ-ын тогтоолын заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:** | | | | |
| **Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, банкны тогтолцооны эрсдэл даах чадварыг сайжруулах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх** | | | | |
| Валютын дотоодын захын дэд бүтцийг хөгжүүлж, ил тод, үр ашигтай байдлыг хангасан шинэ тогтолцоо бүрдүүлэх; | 1 | BMATCH платформын үйл ажиллагааны талаар удирдлагад танилцуулж, үр дүнд үндэслэн цаашид үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэнэ | I улирал | ЗЗГ (МТГ) |
| | 2 | Монголбанкны бусад холбогдох газруудтай хамтран валютын дотоодын захын дэд бүтцийг хөгжүүлэх санал боловсруулах, саналыг удирдлагад танилцуулсны үндсэн дээр холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх | Жилийн турш | ЗЗГ (МБГ, ТТБГ, МТГ, ЭУА) |
| Санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийн эрх зүйн орчныг бүрдүүлэх; | 3 | Активын удирдлагын мэргэшсэн инситуцийг бий болгож, зээлийн хоёрдогч захыг хөгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлнэ | Жилийн турш | ХЭЗГ (ХШГ, ТТБГ) |
| Санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгууртай болгох, санхүүгийн зуучлалыг хүртээмжтэй болгох ажлыг эрчимжүүлэх; | 4 | Монгол Улсын санхүүгийн зах зээлийн 2025 он хүртэлх хугацааны шинэчлэл, хөгжлийн хөтөлбөрийг СТБЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна | IV улирал | СТБЗАА |
| | 5 | Арилжааны банкуудыг нээлттэй хувьцаат компани болгож хувьцааг нь хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй байдлаар арилжаалах боломжийн талаар СТБЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох арга хэмжээний санал, дүгнэлт, зөвлөмж гаргана | IV улирал | СТБЗАА (ХШГ) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 6 | Монгол Улсын банкны зах зээлийн нээлттэй байдал, өрсөлдөөнийг сайжруулах талаар СТБЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох арга хэмжээний санал, дүгнэлт, зөвлөмж гаргана | II улирал | СТБЗАА (ХШГ) |
| Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль зүйн зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох; | 7 | Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг холбогдох байгууллагаас ирүүлсэн зөвлөмж болон олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох, шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг бэлтгэнэ | Жилийн турш | СМА (ХЭЗГ) |
| Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгон хөгжүүлэх, ипотекийн зээлийн хөтөлбөрийг макро эдийн засгийн төлөв байдалтай уялдуулан урт хугацаанд хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх; | 8 | Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийг зах зээлийн зарчимд нийцүүлэн Төрийн зохистой оролцоог хангаан оновчтой хувилбараар хэрэгжүүлэх санал боловсруулж Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллана | Жилийн турш | МБГ |
| | 9 | Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийг боловсронгуй болгох зорилгоор олон улсын туршлага судлах, шаардлагатай тохиолдолд шийдвэрийн төсөл бэлтгэн удирдлагад танилцуулна | I улирал | МБГ (ЗЗГ) |
| **Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл** | | | | |
| **1. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:** | | | | |
| Мөнгөний бодлогын зах зээлд суурилсан хэрэгслийг ашиглан хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2017-2019 онд жилийн 8 хувиас дээшгүй түвшинд байлгана. | 10 | Мөнгөний бодлогын шийдвэр гаргалтад шаардлагатай макро эдийн засгийн ирээдүйн төсөөлөл, мөнгөний бодлогын шинжилгээг цогцоор нь боловсруулна | МБЗ хуралдах бүр | МБГ (МБХ) |
| | 11 | Инфляцийн төсөөлөл, макро эдийн засгийн ирээдүйн төлөвийг тусгасан, инфляцийн зорилт болон эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогын хувилбаруудыг агуулсан бодлогын саналыг боловсруулж, Мөнгөний бодлогын зөвлөлд танилцуулна | МБЗ хуралдах бүр | МБГ (МБХ) |
| | 12 | Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл, түүний үндэслэл, танилцуулгыг нэгтгэн боловсруулах, тооцоо судалгаа хийнэ | III улирал | МБГ (МБХ) |
| | 13 | Макро эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв байдлыг тусгасан “Инфляцийн төлөв байдлын тайлан”-г бэлтгэж, олон нийтэд мэдээлнэ | Улирал бүр | МБХ, МБГ |
| | 14 | Иргэд, судлаачид болон банкны эдийн засагчдын инфляцийн талаарх хүлээлтийг тодорхойлох түүвэр судалгааг хийж тайлагнана | Улирал бүр | ССГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэн, уян хатан тогтох зарчмыг баримтална. | 15 | Экспортын голлох түүхий эдийн зах зээлийн төлөв байдлын талаарх шинжилгээг боловсруулж, удирдлагад танилцуулна | Улирал бүр | ЗЗГ |
| | 16 | Хятадын Ардын Банктай үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн хугацааг сунгах, хэмжээг нэмэгдүүлнэ | I улирал | ЗЗГ |
| | 17 | Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь хүчин зүйлстэй нийцтэй тогтож буй эсэхийг судалж, мөнгөний бодлогын шийдвэр гаргахад ашиглана | Жилийн турш | МБГ (ССГ) |
| | 18 | Экспортын бүтээгдэхүүний хувьд бодит ханшийг тооцож, өрсөлдөх чадварыг тодорхойлон валютын ханшийн бодлогын шийдвэр гаргалтанд ашиглана | Жилийн турш | МБГ (ССГ) |
| Эдийн засгийн гадаад орчинд гарч болзошгүй огцом өөрчлөлтийг төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн уян хатан бодлого, мөнгөний бодлогын арга хэрэгслийг ашиглан зохицуулж, гадаад валютын улсын нөөцийг зохих түвшинд хүргэн нэмэгдүүлнэ. | 19 | Эдийн засгийн гол түнш орнуудын төв банкуудтай үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцэл хийх, хугацааг сунгах, хамтын ажиллагааг идэвхижүүлнэ | Жилийн турш | ЗЗГ |
| | 20 | Гадаад валютын улсын нөөцийн хүрэлцээт байдлыг тогтвортой хадгалах, нийт нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд гадаад болон дотоод эх үүсвэрийг татан ажиллана | Жилийн турш | ЗЗГ |
| **2. Санхүүгийн салбарын тогтвортой байдлын хүрээнд:** | | | | |
| Санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор системийн тогтвортой байдлын үнэлгээг олон улсын санхүүгийн байгууллагатай хамтран гүйцэтгэж, макро зохистой бодлогыг хэрэгжүүлнэ. | 21 | ОУВС-гийн “Financial Sector Assessment Program (FSAP)” хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын санхүүгийн салбарын үнэлгээг тус байгууллагаар гүйцэтгүүлж, хөтөлбөрийн үр дүнд өгсөн зөвлөмжид үндэслэн цаашид авах арга хэмжээний санал боловсруулна | Жилийн турш | СТБЗАА (ХШГ) |
| | 22 | Нийт санхүүгийн салбар, системийн ач холбогдол бүхий банк санхүүгийн байгууллагыг хямралд хүргэж болзошгүй эрсдэлийг нарийвчлан тодорхойлж, авах арга хэмжээний санал боловсруулна | Жилийн турш | СТБЗАА (ХШГ) |
| | 23 | Санхүүгийн салбарын үр ашиг, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, санхүүгийн салбарын дэд бүтэц, хууль эрх зүйн акт, төлбөр тооцооны системийг боловсронгуй болгоно | Жилийн турш | СТБЗАА (ХШГ, ХЭЗГ, ТТБГ) |
| | 24 | Санхүүгийн системийн эрсдэлийг бууруулах үүднээс мөчлөг сөрсөн макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоо бий болгоно | Жилийн турш | СТБЗАА (ХШГ) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 25 | ТМБҮЧ-ийн хэрэгжилт, биелэлтийг олон нийтэд тогтмол сурталчлах, холбогдох мэдээ, мэдээллийг хүргэх ажлыг зохион байгуулна | Жилийн турш | ОНБМТ, Холбогдох газрууд |
| | 26 | Мөнгөний бодлогын хэрэгсэлд макро зохистой бодлогын хэрэгслүүдээс нэвтрүүлж болох боломжийг судлах, шаардлагатай тохиолдолд ашиглана | Жилийн турш | МБГ |
| Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх болон эрсдэл даах чадварыг хадгалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. | 27 | Монголбанкны бие даасан, хараат бус байдлыг хангах зорилгоор холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоно | Жилийн турш | ХЭЗГ |
| | 28 | Төлбөрийн системийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг шинээр боловсруулна | Жилийн турш | ТТБГ, ХШГ |
| | 29 | “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийн хүрээнд үр ашигтай, найдвартай, харилцан уялдаа бүхий төлбөрийн системийн дэд бүтцийг бий болгоно | Жилийн турш | ТТБГ |
| | 30 | Эрдэнэсийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна | Жилийн турш | ХЭЗГ, ЗЗГ |
| | 31 | Векселийн тухай хуулийн шинэчилсэн найруулгийг оруулна | Жилийн турш | ХЭЗГ, МТГ, ТТБГ |
| | 32 | Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгийг оруулна | Жилийн турш | ХЭЗГ, ЗЗГ |
| | 33 | Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна | Жилийн турш | ХЭЗГ |
| | 34 | Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн боловсруулж УИХ-д өргөн мэдүүлнэ | Жилийн турш | ХЭЗГ (ХШГ) |
| | 35 | Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг төрөлжүүлэн олгох эрх зүйн орчныг боловсронгуй болгоно | Жилийн турш | ХЭЗГ |
| | 36 | Банкны салбарын тогтвортой байдлын үнэлгээг ОУВС-тай хамтран гүйцэтгэнэ | I улирал | ХШГ |
| | 37 | Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны цаашдын хөгжлийн хандлагыг тодорхойлж, мэдээллийн агуулга, бүтэц, эрх зүйн орчныг оновчтой болгох арга хэмжээг авна | Жилийн турш | ХШГ |
| | 38 | Банкны эрсдэл даах чадварын стресс тестийг гүйцэтгэж, үр дүн, авах арга хэмжээний саналыг удирдлагуудад танилцуулна | Хагас жил | ХШГ |
| | 39 | Активын удирдлагын тогтолцоог хөгжүүлэх, холбогдох эрх зүйн орчин бий болгох ажлыг Азийн хөгжлийн банктай хамтран үргэлжлүүлнэ | Жилийн турш | ХШГ |
| | 40 | Төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй, үр ашигтай ажиллагааг хангаг ажиллана | Жилийн турш | ТТБГ |
| **3. Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулах үүднээс Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлж, зөвлөлийн гишүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | 41 | Эдийн засаг, санхүүгийн хямралын үе дэх санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдийн үүрэг оролцоо, хамтын ажиллагааг нарийвчлан тусгасан “хямралын үеийн удирдлагын тогтолцоо /crisis management framework/”-г бий болгох чиглэлээр ОУ-ын байгууллагуудтай хамтран ажиллана | Жилийн турш | СТБЗАА |
| | 42 | СТБЗ-ийн гишүүнээр Хадгаламжийн даатгалын корпорацийг элсүүлэх эсэх асуудлыг СТБЗ-ийн хуралдаанаар шийдвэрлэж, гишүүдийн үүрэг оролцоог нарийвчлан тодорхойлно | I улирал | СТБЗАА |
| Монголбанкны бие даасан, хараат бус байдал, валют, үндэсний төлбөрийн системийн зохицуулалтыг боловсронгуй болгоно. | 43 | Монголбанкны 5 шинчлэлийн хүрээнд Төв банкны бие даасан, хараат бус байдлыг олон нийтэд тайлбарлан, сурталчлах ажлыг зохион байгуулна | Жилийн турш | ОНБМТ, Холбогдох газрууд |